



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.10.24 № МЭГ/2958
танай _____-ны № _____-т

**Асуулгын хариу хүргүүлэх
тухай**

Танаас 2025 оны 43 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад тавьсан асуулгын хариуг Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Танд үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 07 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255016065

ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Танаас ирүүлсэн асуулгын дагуу дараах мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна.

1. Өрхийн амьжиргааны түвшинг нарийвчлан тооцсон тооцоолол /сүүлийн 4 жилийн байдлаар/, амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл

1.1. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2012 онд шинэчлэн баталсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг” гэж заасан. Хуульд заасны дагуу ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай өрхийг тодорхойлох зорилгоор Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг ҮСХ-ноос хийдэг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнд үндэслэн 2010, 2013, 2016, 2022 онд тус тус баталсан.

Энэхүү аргачлал нь албан бус салбарт ажиллагсад олонтой, орлогыг шууд тооцох боломжгүй, өрхийн орлогын талаарх бүрэн мэдээлэл байхгүй үед амьжиргааны түвшинг төлөөлж чадахуйц хувьсах үзүүлэлтүүдээр тодорхой загварын дагуу үнэлдэг, дэлхийн олон улс орнуудад ашигладаг.

“Аргачлал шинэчлэн батлах тухай” Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 дүгээр хамтарсан тушаалаар 2022 онд батлагдсан аргачлалд “Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал” гэсэн гуравдугаар хавсралтыг нэмж баталсан. Гуравдугаар хавсралтаар батлагдсан аргачлал нь хүн амын чинээлэг хэсгийг тодорхойлох, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд олгохтой холбоотой байсан.

2022 онд батлагдсан “Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал” нь 2 үе шаттай. Эхний үе шатанд төрийн мэдээллийн сангаас ядуурлын түвшинг тогтооход илүү хамааралтай өрхийн бүтэц, малын тоо, тээврийн хэрэгсэл, нийгмийн хамгаалал, татвар гэх мэт 6 төрлийн 50 хувьсах үзүүлэлтийн дагуу захиргааны мэдээлэлд суурилан өрхийн амьжиргааны түвшинг үнэлсэн.

Үүний дагуу 2025 оны 9 дүгээр сард Монгол Улсын нийт 1,030,721 өрхийн 3,505,419 иргэний мэдээллийг төрийн мэдээллийн холбогдох сангаас нэгтгэн, өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх ажлыг бүрэн хийсэн. Эдгээрээс 210.7 мянган өрхийн 935.5 мянган иргэн нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн гэж тодорхойлогдсон. Аргачлалын 2 дахь үе шатанд амьжиргааны түвшний босго шугамаас доогуур орлоготой 104,505 өрхөөр зочлон, судалгаанд хамруулж, өрхийн амьжиргааны түвшинг үнэлсэн.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд суурилан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд халамжийн сангаас хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, онцгой тохиолдлын тэтгэмжүүдийг олгож байна. Мөн бусад хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөх, төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ, их дээд сургуулийн төлбөрийн болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны үнийн хөнгөлөлт зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

Дэлхийн банкнаас 2025 онд танилцуулсан “Монгол Улсын төсвийн судалгаа”-нд “... Орлогыг шууд тооцох аргыг нэвтрүүлэх нь урт хугацаандаа хүрэх зорилт байж болох ч өгөгдлийн хязгаарлагдмал байдал, албан бус секторын хүрээ өргөн зэрэг өнөөгийн нөхцөлд захиргааны мэдээлэл ба өрхийн судалгааг хослуулж өрхийн орлогыг тооцох арга нь завсрын практик шийдэл болох юм” гэж дурджээ.

Цаашид нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зорилтот бүлгийг зөв тодорхойлох, зарим төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамруулахдаа өрхийн амьжиргаатай уялдуулахаар тусгасан. Мөн хуулийн төсөлд амьжиргаа багатай өрхийн хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлээгүй гишүүнийг хөдөлмөр эрхлүүлэх, бие даан амьдрах чадавхыг дэмжих үйлчилгээ үзүүлэхээр тусгасан.

1.2.Амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар:

Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн чиглэлийн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай (2010 он), Нийгмийн халамжийн тухай (2012 он), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (2016 он), Ахмад настны тухай (2017 он), Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай (2017 он), Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай (2017 он) 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нийгмийн халамжийн сангаас 2024 онд нийт 2.3 их наяд төгрөг зарцуулснаас нийт зардлын 26.4 хувь буюу 600.9 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжид зарцуулжээ. Үүнээс 530.0 тэрбум төгрөг нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулагдсан байна.

Харин 1,704.1 тэрбум төгрөг буюу нийт зардлын 73.6 хувийг 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, одонтой эх, хүүхдийн мөнгө, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг олгож байгаа хөтөлбөрт зарцуулжээ.¹ Өөрөөр хэлбэл нийгмийн халамжийн нийт зардлын дийлэнх хэсэг нь 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, хүүхдийн мөнгө, одонтой эхийн болон жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг эх, хүүхдэд чиглэсэн нийтлэг мөнгөн тэтгэмжид зарцуулж байна.

Дэлхийн банкнаас 2025 онд танилцуулсан “Монгол Улсын төсвийн судалгаа” гэсэн тойм судалгааны нэг бүлэг нь Нийгмийн халамжийн тогтолцооны үр ашиг, дэвшилтэт шинжийг сайжруулах асуудлаар судалгаа хийсэн. Уг судалгаанд “2022 онд нийгмийн халамжийн зардал улсын төсвийн 11.1 хувь, ДНБ-ний 3.7 хувийг эзэлж, хүн амын бараг 90 хувь, түүн дотроо хамгийн ядуу 20 хувийн бараг бүх хүн шууд ба шууд бус байдлаар ямар нэг хэлбэрийн тэтгэмж, дэмжлэг авсан байна.” гэжээ. Судалгаанд

¹ Нийгмийн халамжийн сангийн 2024 оны тайлан, ХХҮЕГ, 2025 он

нийгмийн халамж нь ядуурал, тэгш бус байдлыг мэдэгдэхүйцээр бууруулж байгаа ч өндөр зардлаар энэ үр дүнд хүрч байна гэж дүгнэжээ.

Мөн уг судалгаанд нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн өгөөж буюу ядуурлыг бууруулахад үзүүлж буй нөлөө харилцан адилгүй байна гээд нийгмийн халамжид зарцуулсан 1 их наяд төгрөг тутамд ядуурлын гүнзгийрэлт 4.5 хувиар буурч байна гэжээ. Мөн ядуурлын гүнзгийрэлтийг бууруулахад үзүүлж буй нөлөө нь нийгмийн халамжийн тэтгэвэр 5.0 хувь, хүүхдийн мөнгөн тэтгэмж 4.4 хувьтай гарсан бол хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хамгийн өндөр буюу 7.7 хувьтай, ахмад настны хөнгөлөлт тусламж болон насны хишиг 1.7 хувь бууруулсан байна гэсэн дүгнэлт гарчээ.

Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь амьжиргаа багатай өрх, иргэдийн амьжиргааны түвшинд суурилан үзүүлдэг ганц үйлчилгээ нь юм. 2024 оны жилийн эцсийн байдлаар уг үйлчилгээнд 89706 иргэнийг хамруулж 13.8 тэрбум төгрөг зарцуулсан нь 2024 оны нийт зардлын ердөө 0.6 хувьтай тэнцэж байна. Тус үйлчилгээнд 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 15,789 өрхийн 83,505 иргэнийг хамруулж 9.3 тэрбум зарцуулсан байна.

Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийг хүн амын бүлгээр авч үзвэл 2024 оны жилийн эцсийн байдлаар ахмад настан 4,002, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 6,825, өрх толгойлсон эх, эцэг 2,218, 0-18 хүртэлх насны 40,742 хүүхэд байна.

Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээний журмыг шинэчлэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/186 дугаар тушаалаар баталсан. Энэ журамд өрх бүрд өрхийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, хүүхдийг сургуульд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх зэргээр салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд өрхийн амьжиргааг сайжруулахаар тусгасан.

Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөр: Тус яамнаас Халамжаас-хөдөлмөрт чиглэх зорилтын хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр нийгмийн халамж шаардлагатай өрхийн гишүүдийг чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсад туршигдаж, үр дүнд хүрсэн “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн 1259 өрхийг хамруулан хэрэгжүүлэх 2022 оноос эхлэн гурван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн.

Уг хөтөлбөрт хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг зорилтот сонгож тэдний орлогыг нэмэгдүүлэх, тогтмол хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, нийгмийн идэвх оролцоог сайжруулах, тухайн иргэний ур чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх сургалтуудыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсны үндсэн дээр өрхөд тохирох бизнесийг санал болгож түүнд нь зохих дэмжлэг үзүүлсэн. Тогтвортой амьжиргаанд хүргэх цогц арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд хамрагдсан өрхийн 80.6 хувь нь төгсөлтийн шалгуурыг хангаж, хөтөлбөрөөс олгосон тоног төхөөрөмжийг ашиглан өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа нь халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын зорилтын бодит үр дүн болж байна. бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээг энэхүү аргачлалын дагуу үзүүлэхээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Ковид-19 цар тахлын үед хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэн нь өрхийн амьжиргааг дэмжих, хоол хүнс болон бусад хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Нэгдсэн Үндэстний байгууллага болон Азийн хөгжлийн банкны хамтарсан судалгаагаар хүүхдийн мөнгийг нэмэгдүүлснээр ядуурлын түвшинг 2020 онд 28.4 хувьд хүрэх байсныг 24.7 хувьд хүргэн бууруулсан гэж дүгнэжээ.

Дэлхийн банкнаас 2025 онд хийсэн “Монгол Улсын төсвийн судалгаа”-нд “... Шууд шилжүүлгүүд, юуны түрүүнд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нөлөөгөөр үндэсний ядуурлын түвшин 13.3 нэгж хувиар, тэгш бус байдал-Жини коэффициент 5.6 нэгжээр буурсан нь дэлхийн хэмжээнд хамгийн өндөр гүйцэтгэлд тооцогдох хөтөлбөр юм.” гэж дурджээ.

Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хөтөлбөрийн нөлөөллийн талаарх талбарын тэмдэглэл”-д “...2023 он гэхэд Хүүхдийн мөнгөний хөтөлбөр нь ойролцоогоор 1.3 сая хүүхдийг хамруулсан бөгөөд нийт зардал нь 1.5 их наяд төгрөгт хүрч, улсын нийт төсвийн зарлагын 5.6 хувь, ДНБ-ний 2 хувийг эзэлжээ. Энэхүү өргөжилт нь ядуурлын түвшинг бараг тал хувиар бууруулсан. Хүүхдийн мөнгөний хөтөлбөр нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн бөгөөд 2010 онд бүх хүүхдэд хүртээмжтэй буюу универсал хэлбэрээр хэрэгжиж байсан үед тэгш бус байдал буурч, Жини коэффициент 35.0 хувиас 32.3 хувь хүртэл буурсан бөгөөд хүүхдийн ядуурлын түвшин 2016 он гэхэд 43.5 хувиас 38.5 хувь болж буурсан байна.” гэж дүгнэсэн байна.

2023 онд хийгдсэн “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт” Монгол Улсын үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэлд “Хүүхдийн мөнгийг 100.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлснээр өрхийн орлого дунджаар 7.1 хувиар нэмэгдсэн бол бага орлоготой 20 хувийн өрхүүдийг орлого хамгийн ихээр буюу 26.3 хувиар нэмэгдсэн байна. Нийт өрхийн хамгийн бага орлоготой 20 хувьд Засгийн газрын шилжүүлгийн эзлэх хувь хамгийн өндөр буюу өрхийн орлогын 32.4 хувийг бүрдүүлж байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмж нэмэгдүүлснээр бага орлоготой өрхүүдийн орлогыг хамгаалахад хамгийн ихээр нөлөөлсөн байна гэж дүгнэж болохоор байна.” гэж дурджээ.

2.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалтын талаарх судалгаа /2020-2025 оны байдлаар хэдэн хүүхдийн хэдэн хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан, тэдгээрийн хэд нь эцэг, эх, асран хамгаалагчийн нэр дээрх данстай холбосон, хэд нь хүүхдийн нэр дээр хадгаламж нээж дансанд байршуулсан/

Нийгмийн халамжийн тухай хуулийн 15.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно.” гэж заасны дагуу хүүхдийн мөнгөн тэтгэмжийг арилжааны банкаар дамжуулан, зөвхөн тухайн хүүхдийн нэр дээр үүсгэсэн Монголбанкны дансны нэгдсэн санд бүртгэлтэй данс руу Төрийн сангаас ямар нэг шимтгэл хураамжгүйгээр сар бүр тогтмол шилжүүлдэг.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдсан хүүхдийн тоо, 2020-2024 он

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Хүүхдийн тоо	1,186,289	1,220,158	Ирээдүйн өв сангаас	1,305,322	1,340,971

Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 236 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу 0-18 хүртэлх насны хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгодог.

Арилжааны банкууд Монгол Улсын Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг баримтлан 18 насанд хүрсэн иргэнд “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай” гэж тооцон данс нээж байна. Харин хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дансыг 18 насанд хүрээгүй хүүхдийг төлөөлөн тухайн хүүхдийн эх, эцэг эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд нээлгэдэг.

Үүнээс гадна хүүхдийн мөнгөн тэтгэмжийг эх, эцэг эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн хүүхдийн дансанд хадгаламж хэлбэрээр байршуулан хадгалж байна. 2021 онд арилжааны банкуудаас авсан мэдээллээр 1,221,517 хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байгаагийн 453,080 хүүхэд буюу нийт хүүхдийн 37.1 хувь нь хүүхдийн мөнгөө банканд хадгалдаг байсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас авсан албан ёсны мэдээллээр 2023 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 96.3 хувийг олгодог арилжааны голлох 4 банкнаас нийт 1,258,279 хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авч байсны 320,695 хүүхэд буюу 26.7 хувь нь хадгаламж хэлбэрээр байршуулан хадгалж, 937,584 хүүхэд буюу 73.3 хувь нь харилцах дансаар дамжуулан авч зарцуулжээ.

3.Хүүхдийн мөнгөний бодит хэмжээг инфляцтай уялдуулсан эсэх талаар хийгдсэн судалгаа

Монгол Улсын хувьд төсвийн нөхцөл боломж, инфляцийн болон хэрэглээний үнийн өсөлтөөс шалтгаалж хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ 2005 онд 3000 төгрөг байсан бол 2020 оноос 100.0 мянган төгрөг болж нэмэгдсэн.

Тухайлбал, 2005 онд Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 3 ба түүнээс дээш хүүхэдтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн 0-18 насны хүүхдэд буюу нийт хүүхдийн 34 хувьд сар бүр 3000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн. 2012 оноос мөнгөн дүнгийн хэмжээг нэмэгдүүлж, Монгол Улсын 0-18 насны нийт хүүхдэд 20 мянган төгрөг олгож эхэлсэн. 2016 онд хүүхдийн мөнгийг зорилтот хэсэгт чиглүүлж, нийт хүүхдийн 60 хувьд, 2018 онд 60-80 хувьд, 2019 онд 80-85 хувьд, 2020 оноос 100 хувь буюу бүх хүүхдэд олгодог болсон.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн бодит үнэ цэнийг 2012 оноос тухай бүр инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж байсан бол тэтгэмжийн хэмжээ 2024 оны үнээр ойролцоогоор 50 мянган төгрөгтэй тэнцэх байсан гэж Дэлхийн банкнаас 2025 онд хийсэн “Монгол Улсын төсвийн судалгаа”-нд дурджээ.

4. 2022 оноос хойш хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан мөнгөн дүн, цаашид хүн амын өсөлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан хөрөнгө:

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
----------	---------	---------	---------	---------	---------

Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	1,053.1	1,336.3	ИРЭЭДҮЙН ӨВ САНГААС	1,520.1	1,540.0
---------------------------------------	---------	---------	---------------------------	---------	---------

Нийгмийн халамжийн сангаас 2024 онд нийт 2.3 их наяд төгрөг зарцуулснаас 1.5 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан байна.

Тус яам нь Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн барихад бэлэн болсон.

Хуулийн шинэчлэлийн хүрээнд амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулахгүй олгодог эх, хүүхдэд чиглэсэн, нийтлэг шинжтэй тэтгэмжүүд болох хүүхдийн мөнгө, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмж зэргийг нийгмийн халамжийн бодлогоос зааглаж, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан.

Олон улсад хийгдсэн судалгаанаас харахад ганц тэтгэмжээр хүн амын өсөлт хангалттай нэмэгддэггүй, харин 1-2 жил зэрэг богино хугацаанд нэмэгдэж болох ч тогтвортой өсөлт гардаггүй гэжээ. Харин эхчүүдийг төрсний дараах удаан хугацааны орлогын, ажлын байрны баталгаагаар хангах, эрүүл мэнд, сургууль, цэцэрлэгийн хүртээмж, чанарыг сайжруулах, залуу гэр бүлийг орон сууцаар хангах, амьдрах орчны таатай нөхцөлийг бүрдүүлэх болон төрөх насны эмэгтэйчүүдийн тоо зэрэг олон хүчин зүйлээс хүн амын өсөлт хамаарна. Иймд хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд ганц тэтгэмжийг нэмэх биш салбар дундын цогц бодлого шаардлагатай байна.

5.Хүүхдийн мөнгийг шууд хэрэглэж байгаа мөнгөний хэрэглээний судалгаа

Тус яамнаас одоогоор хүүхдийн мөнгийг шууд хэрэглэж байгаа эсэх болон хүүхдийн мөнгөний хэрэглээний талаар судалгаа хийгээгүй бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үр нөлөөний судалгааг 2026 онд хийхээр тусгасан.

Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 236 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын 5.1 дэх хэсэгт “Өрхийн гишүүн-иргэн хүүхдийн мөнгийг согтууруулах ундаа, тамхины хэрэглээнд зарцуулахгүй байх үүрэг хүлээнэ.” гэж, 5.2 дахь хэсэгт “Хүүхдийн мөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны зээлд суутгахыг хориглоно.” гэж тус тус заан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тухайлбал, эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг зөрчсөн талаар аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэн түдгэлзүүлсэн хугацаанаас тооцож үргэлжлүүлэн олгох зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлж байна.

6. “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолын 2 дахь дэд заалтад “хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхдийн мөнгөн хуримтлал болон бусад хэлбэрээр хадгалах, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгох” гэж заажээ. Үүнтэй холбоотой хийгдэж буй ажлын талаарх мэдээлэл

Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийн төсвийн зардлыг Сангийн сайдын төсвийн багцад тусган, хүүхдийн мөнгөн хуримтлал хэлбэрээр 2022 онд хэрэгжүүлсэн.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд “9¹ дүгээр зүйл. Хүүхдийн мөнгөн хуримтлал” зүйлийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөхөөр тусгасан. Үүний дагуу 2022 оны 12 дугаар сарын байдлаар 30748 хүүхэд хуримтлал үүсгэж, хүүхдийн мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин энэ хуримтлалд Төрийн санд хүү тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй байснаас дээрх иргэд гомдол гаргаж, нөгөө талаар хуулийн үйлчлэл дууссан тул хүүхдийн мөнгөн хуримтлал үүсгэсэн 30748 хүүхдийн хуримтлуулсан 3.1 тэрбум төгрөгийг 2023 болон 2025 онуудад буцаан олгосон.

Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 236 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор Хүүхдийн төлөө санд хүүхдийн мөнгөө хандивлах зохицуулалтыг тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд уг заалтын хүрээнд 502 хүүхдийн 107.9 сая төгрөгийг Хүүхдийн төлөө санд шилжүүлсэн байна.

“Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д Засгийн газрын 2024 оны 121 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж төрөлжсөн асрамжийн газарт амьдарч байгаа 14 хүртэлх насны хүүхэд бүрд тухайн асрамжийн газар нь хадгаламжийн данс нээлгэж, хүүхдийн мөнгийг банканд бүрэн хадгалуулах, харин 14 ба түүнээс дээш насны хүүхэд бүрд хүүхдийн мөнгөний 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий харилцах дансыг нээлгэх зохицуулалт тусгасан. Ингэснээр асрамжийн газрын хүүхдэд мөнгөн тэтгэмжийг хуримтлуулах боломжийг бүрдүүлсэн.

2025 оны эхний хагас жилийн байдлаар асрамж халамжийн төвд асруулж байгаа 752 хүүхдэд хуримтлал үүсгэсэн байна. Мөн 14-өөс дээш насны 227 хүүхэд хүүхдийн мөнгөнийхөө 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий харилцах дансыг нээлгэн ашиглаж байна. Асрамж халамжийн байгууллагаас хүүхдэд санхүүгийн мэдлэг, боловсрол олгох 39 удаагийн сургалтыг 2024-2025 онд зохион байгуулж, 481 хүүхдийг хамруулсан байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ